



Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ

2025 оны 4 дүгээр сарын 08-ний өдөр шинэчлэн батлагдсан зохион байгуулалтын бүтцийн дагуу 2026 онд Гүйцэтгэх захирал, 1 газар, 5 хэлтэст нийт 31 орон тоотой ажиллахаар төлөвлөснөөс 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар удирдах болон гүйцэтгэх орон тооны 22 ажилтантайгаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Компанийн Ерөнхий нягтлан бодогч өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор ажлаас чөлөөлөгдсөнөөр хүний нөөцийн нээлттэй сонгон шалгаруулалтыг Ерөнхий нягтлан бодогчийн ажлын байранд ажлын байранд 2026 оны 1 дүгээр сарын 12-оос 2 дугаар сарын 05-ны өдрийн хугацаанд, хууль, эрх зүй, санхүү шинжилгээний чиглэлээр ажлын байрны зайлшгүй шаардлагатай сул орон тоонд 2026 оны 06 дугаар сарын 11-ээс 25-ны өдрүүдэд холбогдох журмын дагуу зохион байгуулан .

Байгууллагын дотоод үйл ажиллагааны зохицуулалт, ил тод байдал, зохион байгуулалтыг сайжруулах, оновчтой болгох зорилгоор дотоод дүрэм журам, хэм хэмжээг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан холбогдох баримт бичгүүдийг шат дараатайгаар шинэчилж, шаардлагатай мэдээ мэдээллийг холбогдох тайлан мэдээллийн системүүдээр дамжуулан дотоодод болон нийтэд хүргэж байна.

Олон нийт, ажилтнуудаас санал, гомдлыг байгууллагын албан ёсны цахим хуудас, цахим хаяг, мөн албан оффис дахь санал хүсэлтийн хайрцгаар дамжуулан хүлээн авч, шийдвэрлэж байна.

Нийт ажилтнуудын санал хураалтын үндсэн дээр “Ёс зүйн зөвлөл”-ийг шинэчлэн байгуулж, байгууллагын “Ёс зүйн дүрэм”, “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг шинэчлэн баталж хэрэгжүүлэн ажиллаж байна.

---oOo---